



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/2/СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот
2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 7058-4204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: У.Энхчимэг

Утас: 7000-3775 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ОНӨААТҮГ НТШ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар Нээлттэй тендер шалгаруулалт



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	12
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.03.15 № 299
танай _____ -ны № _____ -т

ЧОЙБАЛСАН ХӨГЖИЛ ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Б.ТЭГШЖАРГАЛ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520298

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтын дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Б.Тэгшжаргал Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 10 -наас 2020 оны 03 дугаар сарын 13-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 14-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорнод аймгийн Төрийн аудитын газрын захиалгаар "Хаан консалтинг аудит" ХХК-ийн аудитор У.Энхчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төрийн аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 31 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас

санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Иргэн аж ахуйн нэгж байгууллагын ажиллаж, амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой **нийцээгүй байна.**

Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acolous программ хангамж ашигладаг байна.

Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 32 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлын үзүүлэлтийг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,026,640.4 мянган төгрөгөөс тооцон 20,532.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг мөн 20,532.8 мянган төгрөгөөр тооцсон болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 171,005.39 мянган төгрөгөөр буюу 7.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	84.50	72.40	(12.10)
Авлага	460.00	-	(460.00)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	32,295.24	49,792.87	17,497.64
Үндсэн хөрөнгө	2,991,042.84	3,162,048.24	171,005.39
Хуримтлагдсан элэгдэл	(1,284,260.19)	(1,346,173.07)	(61,912.88)
Нийт хөрөнгө	1,739,622.38	1,865,740.44	126,118.06
Өр төлбөр	188,332.62	161,529.73	(26,802.89)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,551,289.77	1,704,210.71	152,920.94
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,739,622.39	1,865,740.44	126,118.05

Бараа материал дансны үлдэгдэл өссөн нь авто замын сангийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн зам засварын тоног төхөөрөмж, материалаар замыг засварыг бүрэн хийж дуусаагүйгээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь үндсэн хөрөнгөнд 385,784.8 мянган төгрөгийн хөрөнгө авснаас шалтгаалжээ. Хөрөнгө оруулалтаар 1,350.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 384,434.8 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 40,927.5 мянган төгрөг, акталсан 130,907.0 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 2017 онд үүссэн богино хугацаат зээлийн өр 157,191.9 мянган төгрөг байгаа нь нийт өр төлбөрийн 97.3 хувийг эзэлж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,704,210.71 мянган төгрөг болж 152,920.94 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгийн өсөлтөөс шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 624,419.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 624,419.8 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 624,419.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 624,419.8 мянган төгрөг буюу 100 хувьтай байгаа байна.

Нэмэлт төсөв: Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 91,242.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 91,242.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 32 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 32 эрсдэл тодорхойлж нийт 32 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 341,620.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 100.3 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 341,520.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 341,620.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 341,620.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Дорнод хүнс компаниас 2 баримтаар 100.3 мянган төгрөгийн хувийн хэрэглээний бараа худалдан авч зардалд бүртгэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 41.2.2 дахь заалттай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

2. Шатахуун, ШТМ-ын төсөвт өртөг нь НТШ зарлах босго үнэтэй байхад үнийн санал авч гэрээ байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.2 -д заасан Энэ хуулийн 8.1.1-д заасан "Босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгөв.

3. Богино хугацаат зээлийн өр нь тооцоо нийлсэн акт байхгүй, гэрээ тодорхойгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д заасан "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай нийцэхгүй, эрх үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгөв.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

НБББББ-ийн хэрэгжилт, худалдан авах ажиллагааг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 35 мэдээллийг хугацаанд нь, 23 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 албан шаардлага хүргүүлснээс албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. НБББББ-тэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тус байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт нийцсэн НБББББ-гүй байна.

1.2. Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааврыг зөрчих эрсдэлтэй.

1.3. Өгсөн зөвлөмж:

Мэргэжлийн аудитын компанитай хамтран НБББББ боловсруулж, мөрдөж ажиллах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

2. Гэрээний биелэлттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилтийг дүгнээгүй байна.

2.2. Эрсдэл:

Гэрээ биелэхгүй, төсвийг үр ашиггүй зарцуулах эрсдэлтэй.

2.3. Өгсөн зөвлөмж:

Гэрээ дууссан тухай бүр дүгнэх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	32,839,738.49	49,865,270.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	84,523.49	72,486.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	52,947.61	64,486.00
31110	Төгрөг	52,947.61	64,486.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	31,575.88	8,000.00
3121	Төгрөг	31,575.88	8,000.00
31211	Төрийн сангийн харилцах	31,575.88	8,000.00
33	АВЛАГА	460,000.00	00.00
335	Бусад авлага	460,000.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	460,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	32,295,215.00	49,792,784.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	30,888,876.00	48,438,285.00
354	Хангамжийн материал	1,406,339.00	1,354,499.00
35410	Бичиг хэргийн материал	229,500.00	404,500.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,176,839.00	949,999.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,706,782,649.12	1,815,875,166.61
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,706,782,649.12	1,815,875,166.61
392	Биет хөрөнгө	1,706,782,649.12	1,815,875,166.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,741,666,693.72	1,741,666,693.72
39202	Хуримтлагдсан элэгдэл	-541,800,780.18	-605,885,835.06
39203	Авто-тээврийн хэрэгсэл	729,206,356.40	822,299,316.40
39204	Хуримтлагдсан элэгдэл	-590,726,583.83	-529,951,488.13
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	6,764,009.00	11,800,373.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-3,174,717.39	-6,306,390.36
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,546,336.00	9,896,336.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,396,443.05	-7,680,237.02
39214	Бусад үндсэн хөрөнгө	503,049,448.91	575,575,517.91
39215	Хуримтлагдсан элэгдэл	-141,351,670.46	-195,539,119.85
39301	Програм хангамж	810,000.00	810,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-810,000.00	-810,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,739,622,387.61	1,865,740,436.61
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	188,332,619.62	161,529,728.92
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	188,332,619.62	161,529,728.92
412	Богино хугацаат зээлийн өглөг	157,191,889.92	157,191,889.92
4121	Төгрөг	157,191,889.92	157,191,889.92
41211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	157,191,889.92	157,191,889.92
413	Өглөг	31,140,729.70	4,337,839.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	580,083.00	163,300.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	30,560,646.70	4,174,539.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,551,289,767.99	1,704,210,707.69
51	Засгийн газрын хувь оролцоо	1,551,289,767.99	1,704,210,707.69
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,651,018,769.00	1,651,018,769.00
51101	Өмч: - төрийн	1,651,018,769.00	1,651,018,769.00
512	Хуримтлагдсан үр дүн	-305,093,547.27	-152,172,607.57
51210	Өмнөх үеийн үр дүн	-305,093,547.27	-305,093,547.27
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	205,364,546.26	205,364,546.26
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,739,622,387.61	1,865,740,436.61

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,420,681,575.46	1,179,561,382.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	53,523,021.00	555,141,550.00
120	Нийтлэг татварын бус орлого	53,523,021.00	555,141,550.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	53,523,021.00	555,141,550.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,114,538.00	61,393,670.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,255,183.00	29,849,397.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,153,300.00	463,898,483.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,367,158,554.46	624,419,832.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	743,689,546.46	00.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	505,378,099.00	552,834,558.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	118,090,909.00	71,585,274.00
1330	Төсвийн захирагчдаас	1,367,158,554.46	624,419,832.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	913,345,343.50	942,768,028.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	913,345,343.50	942,768,028.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	909,701,783.50	938,045,768.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	355,629,294.00	364,613,898.00
210101	Үндсэн цалин	355,629,294.00	364,613,898.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,960,121.01	52,527,665.04
210201	Тэтгэврийн даатгал	29,185,525.22	30,792,078.04
210202	Тэтгэмжийн даатгал	2,931,696.38	3,622,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,992,024.38	10,143,273.00
210204	Ажилгүйдлийн даатгал	713,716.86	724,520.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,137,158.17	7,245,194.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,933,994.00	7,198,416.25
210301	Гэрэл, цахилгаан	4,279,437.00	3,591,171.25
210302	Түлш, халаалт	2,738,400.00	2,409,400.00
210303	Цэвэр, бохир ус	556,157.00	837,845.00
210304	Байрны түрээс	360,000.00	360,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	170,556,053.30	190,088,927.20
210401	Бичиг хэрэг	1,599,130.00	4,496,289.00
210402	Тээвэр, шатахуун	167,413,546.30	184,328,689.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,543,377.00	1,263,949.00
2105	Нормативт зардал	7,350,883.00	17,692,405.00
210502	Хоол, хунс	4,196,916.00	1,323,669.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,153,967.00	16,368,736.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	70,503,900.20	70,313,336.80
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,419,248.00	8,426,826.00
210604	Урсгал засвар	63,084,652.20	61,886,510.80

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,359,875.00	4,303,098.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж	604,000.00	332,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,714,575.00	901,098.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	807,400.00	670,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	390,000.00	330,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	43,900.00	56,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	242,407,662.99	231,080,822.01
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,560,984.64	38,260,906.50
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	211,846,678.35	192,819,915.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,643,560.00	4,722,260.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,643,560.00	4,722,260.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,643,560.00	4,722,260.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	507,336,231.96	236,793,353.70
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	262,284,808.96	83,872,414.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	262,284,808.96	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-262,284,808.96	-83,872,414.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	245,051,423.00	152,920,939.70

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	702,204,150.00	742,028,269.19
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	57,603,250.00	97,428,869.19
120	Нийтлэг татварын бус орлого	57,603,250.00	97,428,869.19
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	57,603,250.00	97,428,869.19
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	44,122,550.00	67,503,109.19
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,480,700.00	29,925,760.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	644,600,900.00	644,599,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	644,600,900.00	644,599,400.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	525,600,900.00	569,005,600.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	119,000,000.00	75,593,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	707,350,075.01	742,040,306.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	707,350,075.01	742,040,306.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	704,577,565.01	737,212,401.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	356,337,537.00	364,654,481.00
210101	Үндсэн цалин	356,337,537.00	364,654,481.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,960,121.01	52,527,665.04
210201	Тэтгэврийн даатгал	28,548,640.70	30,792,078.04
210202	Тэтгэмжийн даатгал	3,568,580.90	3,622,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,992,024.38	10,143,273.00
210204	Ажилгүйдлийн даатгал	713,716.86	724,520.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,137,158.17	7,245,194.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,861,656.00	7,847,671.00
210301	Гэрэл, цахилгаан	4,643,908.00	3,949,361.00
210302	Түлш, халаалт	3,012,240.00	2,650,340.00
210303	Цэвэр, бохир ус	845,508.00	887,970.00
210304	Байрны түрээс	360,000.00	360,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	157,193,241.00	209,044,592.00
210401	Бичиг хэрэг	1,112,291.00	4,952,370.00
210402	Тээвэр, шатахуун	154,431,207.00	199,031,115.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,649,743.00	1,311,107.00
2105	Нормативт зардал	13,126,996.00	9,519,185.00
210502	Хоол, хүнс	2,897,200.00	977,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,229,796.00	8,541,285.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	74,572,805.00	78,950,735.00
210602	Тавилга	988,990.00	5,390,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	8,337,680.00	10,295,011.00
210604	Урсгал засвар	65,246,135.00	63,265,724.00



2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,338,475.00	4,169,898.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	543,600.00	298,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,714,575.00	901,098.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	807,400.00	670,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	429,000.00	330,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	43,900.00	56,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,186,734.00	10,270,974.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,013,734.00	6,400,039.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,173,000.00	3,870,935.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,772,510.00	4,827,905.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,772,510.00	4,827,905.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,772,510.00	4,827,905.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-5,145,925.01	-12,037.49
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-5,145,925.01	-12,037.49
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,230,448.50	84,523.49
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	84,523.49	72,486.00



4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,651,018,769.00	205,364,546.26	-305,093,547.27	00.00	1,551,289,767.99
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,651,018,769.00	205,364,546.26	-305,093,547.27	00.00	1,551,289,767.99
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,651,018,769.00	205,364,546.26	-305,093,547.27	00.00	1,551,289,767.99
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	152,920,939.70	00.00	152,920,939.70
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,651,018,769.00	205,364,546.26	-152,172,607.57	00.00	1,704,210,707.69

